

# Living the

# LOTUS

## Buddhism in Everyday Life

1  
2017

VOL. 136

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ҮГ

### Өөрийн үйлээ тултал нь хийдэг хүн

Удаан хугацааны туршид шашин шүтлэгтэй амьдарч дасаад ирэхээр гадаад үзэмж нь туйлын сүсэг бишрэлтэй харагдавч дотоод сэтгэл нь тийм биш байх хандлагатай болж ирдэг.

Гар хавсаргаж буюу хэлбэрийн хувьд харилцагчийнхаа бурханлаг сэтгэлд залбирч байвч сэтгэл дотроо бол “энэ хүн чинь хэлсэн зүйл болгонд эсэргүүцдэг, хэцүү хүн дээ” гэж бодоостой байвал харилцагч тань хэзээ ч танд сэтгэлээ нээхгүй.

Цагаан Лянхуа сударт насад Зэвүүцэхгүй Бодисатвагийн мөргөж залбирах үйлийн тухай айлддаг. Тэрбээр ямар ч хүн байсан “бурханлаг

чанартай, гарцаагүй гэгээрлийн хутгийг олно” хэмээн бат итгэн бусдад мөргөдөг. Тиймээс өөдөөс нь чулуу шидсэн ч, таягаар цохьсон ч “та ямар зүйл хийсэн ч таньд би итгэж байгаа тул эргэлзэхгүй байна. Та гэгээрлийн хутгийг олох л болно” гэж мөргөсөөр байдаг. Нөгөө хүн нь хичнээн утга учиргүй зүйл хэлсэн ч түүнд нь үл автана. Зүгээр л өөрийн “мөргөх үйлээ” тултал нь үргэлжлүүлэн хийнэ.

Ийм хүнтэй учирсан хүн бууж өгөхөөс өөр арга байдаггүй бололтой. Өөрийн эрхгүй сэтгэлийн чанадад нуугдсан сүүн цагаан сэтгэл оргилон гардаг буй за.

Үүсгэн байгуулагчийн үг 9, Х132-133

#### Living the Lotus Vol. 136 (2017.1)

**Хэвлэсэн:** Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

**Хаяг:** Fumonkan, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

**TEL:** +81-3-5341-1124

**FAX:** +81-3-5341-1224

**Email:** [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

**Ахлах редактор:** Мизүтани Шёокоо

**Редактор:**

**Орчуулсан:**

**Эхийг хянасан:** Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*



## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СУРГААЛ

### Эгэл даруу гэхдээ эрч хүчтэй

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч  
Нивано Ничикоо

#### Дэлхий ээжээс суралцах нь

“Жилийн өнгө шинийн нэгэнд харагддаг” (Орч. Монгол хэлний “Гараа сайн бол бариа сайн” гэдэг хэлц үгтэй утгаараа ойролцоо) гэлцдэг. Жилийг угтахдаа “энэ жил ийм байгаасай” хэмээн бодож, зорьсноор бидний сэтгэл эрчлэгдэж, цог жавхаатай оноо эхлүүлж болдог билээ.

Гэтэл шинийн нэгэндээ тавьсан зорилгоо 3 хоног уу гүй юу ажлын ихдээ тэр үү, мартчихдаг. Магадгүй, үүний цаана тогтмол хичээл зүтгэлээс илүү үр дүнг илүүд үзэх сэтгэл хийгээд шинэ зүйлийг эхлүүлэх цаг зав байхгүй зэрэг нөхцөл байж болох юм.

Хиронака Хаккоцүгийн “Шинийн нэгэн байсан ч цасыг цэвэрлэх хэрэгтэй” гэсэн шиг ямар ч үед байсан хийх ёстой зүйлээ сайн хийх сэтгэлийн тэнхээ, тайван байдлыг өөртөө бий болгох нь өнөөгийн бидэнд нэн шаардлагатай зүйл болов уу. Цагаас цаганд баригдаж, үр дүн, ашиг хонжоогоор сэтгэлээ дүүргэж биш, өдөр тутмын ажлаа эгэл даруухнаар гэхдээ эрч хүчтэйгээр хийх. Үүнд чинь л хүн шиг амьдрал, жинхэнэ аз жаргал байдаг гэж би бодном...

“Яарч түргэтэхгүй, налайж залхуурахгүй, зогсолтгүй үйлээ хийх явцад хүнийхээ хувьд хөгжих учиртай болов уу.

“Бага багаар, аажим аажмаар хар чавга нь хатаасан чавга болно” (Иваки Шюүн) (Орч. Монгол ахуйн хувьд нар салхинд дүүжилж хатаан иддэг борц шиг, Япон ахуйд илүү гарсан ургацаа нөөцлөх зорилгоор хатаадаг.) хэмээх байгалийн үйлчлэл хийгээд хүмүүн бидний амьдралыг зүйрлэсэн мөрт нь нэгийг бодогдуулна. Сайн хатсан борц, сайн боловсорсон хүн хоёр аар саархан зүйлийг ч жижиг гэлтгүй өдөр тутмын ажлаа хариуцлагатай хийсний үр дүнд бий болдог гэх үү.

Японд 1 сард цагаан сар тохиодог бөгөөд 1 сар гэхээр чимэглэл болгон хэрэглэгддэг хөөрхөн Фүкүжүсоү цэцгийг санах юм. Дээр иш татсан мөртөөс гадна Фүкүжүсоү цэцэгтэй холбоотой нэг мөрт танилцуулья. “Газар тэнгэрийн ивээл дор Фүкүжүсоү цэцэг дэлбээлсээр, он жилүүд өнгөрсөөр”(Ниномия Сонтोकү). Эх дэлхий өөрийн жамаараа эргэх бөгөөд Язгуурын Үнэний үйлчлэлийн тохироо бүрдэх цагт цэцэг цоморлигоо нээдэг гэдэг. Энэ мөртөөс ч гэсэн хийх ёстой зүйлээ тууштай хийж амьдрахыг зааж сургажээ.



## Зорилгоо тодорхой болгох

Нүдэнд харагдах олз ашиг, гарз хохирол захирагдалгүй, тайван бөгөөд хийх ёстой зүйлээ яс хийх. Ингэж чадвал, ямагт амар амгалан байгаад зогсохгүй, хүнийхээ хувьд өсөж дэвжих боломжтой. Гэвч зорьсон үйлээ үргэлжлүүлэх гэдэг тун ч хэцүү болохыг бид бодит амьдралын жишээнээсээ олонтаа хардаг. Эгэл даруу амьдрах гэдэг утгаараа Шагжамуни бурханг үлгэрлэж болох юм. Гэвч түүнийг үлгэрлэнэ гэхээр, тусгай ур чадвар, зан чанартай байх ёстой мэт санагдана.

Японы бурханы шашины томоохон урсгалын багш Доогэнээс бурханы мөрөөр замнах үйлд юу хамгийн чухал вэ гэж асуужээ. Тэрбээр, “Ном буюу дармаг сурахад авьяас хэрэггүй. Зорилго тавьж өөрийн хэмжээнд тааруулан суралцах үйлдээ шамдвал, гарцаагүй номыг олмуй.” хэмээн итгэлтэй хариулжээ. Мөн “ямагт хүсч тэмүүлүүштэй” буюу дахин дахин хүсч тэмүүлж, эрж хайх сэтгэл нэн чухал гэжээ. Энийг тэрийг хийе гэж бодовч суурь “үнэнч тэмүүлэл” үгүй аваас урт үргэлжлэхгүй гэсэн үг биз ээ.

Өөр өнцөгөөс харвал, зорилгодоо хөтлөгдөн явах үед учирч буй зүйлд нэг бүрчлэн сэтгэлээсээ хандаж чадвал хийж буй үйлдэл нь хэдий эгэл даруу мэт боловч гарцаагүй үр жимсээ өгөх өдөр ирнэ гэсэн үг. Мөн зорилготой хүн аливаа зүйлийн өөрчлөлтөнд баярлах буюу бухимдахгүй сэтгэлийн тэнхээтэй байх бөгөөд тайван уужуу даруу төлөв амьдрахад ч гэсэн нөлөөлөх болно.

Гэвч зорилгод хүрэх хэрэгжүүлэлт гэдэг тухайн хүнээс шалтгаалж тус бүрнээ өөр өөр байж болох юм.

Хог түүх, хэмнэхийг хичээх, “1. мэндлэх, 2. хариу хэлэх, 3. хэрэглэсэн зүйлээ буцаан тавих буюу гутлаа байранд нь тавих” гэсэн нийгэмлэгийн гишүүддээ байнга хэлдэг “3 хэрэгжүүлэлт” ч байж болох юм. Өөрсдийн хийж чадах зүйлээ тогтмол, болж өгвөл хүний нүдэнд өртөөд байхааргүйгээр хэрэгжүүлэх явдал чухал бөлгөө.

Би ч гэсэн, та ч гэсэн, өдөр бүрээ хайрлан нандигнаж, энэ оноо сайхан, талархууштай үдэх болтугай.

Косей сэтгүүл 1-р сарын дугаараас





## Дургүй хадам ээж маань үнэндээ намайг бодисадва болгон хүмүүжүүлсэн бурхан

Рисшё Косей кай, Солонгос нийгэмлэг  
Гишүүн Жи Ок Бүн

Энэхүү илтгэл нь 2016 оны 8 сарын 23нд Солонгосын РКК нийгэмлэг дээр тавигдсан болно.

Миний бие одоогоор шүнин буюу хэсгийн ахлагчийн үүргийг гүйцэтгэж байгаа. 1949 онд ах дүү 7-н хүүхдийн 3 дахь нь болж хорвоод мэндэлсэн. Гэрлэснийхээ дараа 2 хүүтэй болсон.

Хоёр дахь хүү маань аль хэдийн гэрлэж тусдаа гарсан ба одоо би нөхөр, том хүүгийн хамтаар амьдарч байна.

Энэ жил 76-тай нөхөр маань байрныхаа хариуцагчийн үүргийг гүйцэтгэхийн хажуугаар олон нийтийн төв дээр ахлагчийн үүргийг давхар гүйцэтгэдэг. Бурханы авралаар нөхөр маань эрүүл чийрэг биетэй хүн, харин миний хувьд удаан хугацааны турш толгойн өвчнөөр шаналж

байгаа билээ. Косей кайтай холбогдсон шалтгаан маань ч тэсэхийн аргагүй толгойн өвчин байсан юм.

Нэг өдөр шалтгаан нь мэдэгдэхгүй гэнэт толгой өвдөж эхлэв. Өдөр ирэх тусам өвдөлт нь улам даамжирч, тайван суухын аргагүй болсон тул эмч дээр очив. Гэвч эмч дээр очсон ч ер эдгэхгүй байсан тул төрөл бүрийн эмчилгээний аргыг хайж, олон эмнэлэгээр явав. Байдал улам дордож, европ эм, уламжлалт эмчилгээний тан 2-г нэг дор ууснаас болж шар өвчин тусч, элэгний өвчнөөсөө болж золтой нөгөө ертөнц лүү явчихсангүй. Нэг хүн гэрийн чинь байгаа газрын энерги муу байна гэж хэлснээс үүдэн өөр газар луу хүртэл нүүж үзэв.

Ийнхүү элдэв аргыг сүвэгчлэн явахдаа 1993 оны намар ойрхон амьдардаг Ли хэсгийн ахлагчийн ятгалагаар Солонгосын Рисшё Косей кай дээр очиж үзэв. Гэвч үнэндээ миний анхны сэтгэгдэл тийм ч сайн байсангүй. Солонгосын буддын сүм хийдээс тэс ондоо байшин барилга, уур амьсгалтай байсан тул элсэн орох хүсэл огт төрөөгүй ба бүр авсан эрхийг харих замдаа хогийн саванд хаяж орхисон юм.

Гэвч тухайн үеийн дүүргийн ахлагч намайг өргөөн дээр очсоноос хойш хэд хэдэн удаа гэрт тэдори хийж ирсэн. Өмнөх тэргүүнээс “чин сэтгэлээсээ итгэн бурханы үйлд шамдах аваас заавал үр дүн гарах болно” хэмээх үгийг сонсоод би 100 өдөр судар уншлага, хоозад оролцохоор шийдэв. Толгойн өвчнөө илааршуулах чин хүсэлтэй байсан тул Солонгосын Рисшё Косей кайн өргөө лүү өдөр бүр явж байсан ч өөртэйгээ хамааралгүй хүний яриаг сонсох нь надад төвөгтэй санагддаг байв. Гэхдээ л ганц өдөр ч алгасалгүй 100 өдрийн үйлээ амжилттай дуусгаж чадсан юм.

Сар бүрийн 1ний амин өдрийн үйл ажиллагаанд тогтмол оролцохоос гадна өвөг дээдсийн номыг уншдаг болов. Энэ бүхний үр дүнд толгойн өвчин маань илааршаагүй ч одоо



Солонгосын РКК дээр илтгэл тавьж байгаа гишүүн Жи Ок Бүн.

ийнхүү амьд байгаадаа талархах сэтгэлтэй болсон юм.

Хооза дээр хэлсэн өмнөх тэргүүний үг бага багаар дотоод сэтгэл рүү минь нэвтрэн орж, бие маань сайжирч байгааг мэдрэх болов.

Ийнхүү толгойн өвчнийхөө ачаар косей кайтай холбогдож, хооза дээр сурсан зүйлс маань миний баялаг болсон юм. Өмнөх тэргүүн “бид байнгын өөрчлөлт дунд амьдарч байгаа болохоор ийнхүү амьд байгаа маань юу юунаас илүү талархууштай зүйл билээ”, “бүх тохиол учрал надад зориулагдсан бурханы сургаал”, “өөрийгөө өөрчилбөл бусад хүмүүс ч өөрчлөгдөнө” гэж байнга айлдана. Түүнчлэн бид бүгдийг сурсан зүйлээ өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлдэг болгохын тулд тэргүүн ширүүндээ ширүүн зөөлөндөө зөөлнөөр зааж өгдөг байлаа.

Косей кайтай учрахын өмнөх би хувиа хичээсэн, “миний л зөв” гэсэн бодолтой байлаа. Өөрийнхөө үзэл бодлыг бусдаар хүлээн зөвшөөрүүлэх гэж тулгаж, хүлээж авахгүй бол уурладаг байв. Толгой өвчин ч нөлөөлсөн болов уу нөхөр, хүүхдүүд маань үргэлж надад санаа тавьж, миний ая тухыг бодож, тааруулан харьцана. Гэтэл би гэр бүлийнхнийхээ тэр сайхан сэтгэлийг ч анзаарах сөхөөгүй явдаг байв. Хэрэв Косей кайтай учраагүй байсан бол би одоо хэрнэ гэр бүлийнхэндээ талархаж мэдэлгүй амьдарч байгаа болов уу.

8-н насаар ах нөхөртэйгээ гэрлэхдээ би 23-тай байсан. Гэрлэлтээ батлуулмагцаа хадам ээжтэйгээ цуг амьдарч эхэлсэн ба эндээс л хадам бэрийн сөргөлдөөн эхэлсэн юм. Хадам ээж маань бусдыг ялж л байж санаа нь амардаг, хүнд ялагдах туйлын дүргүй хүн байв. Санаанд нь нийцэхгүй зүйл гарвал шууд л уурлаж, хэрэлдэнэ. Гадаа дуу чимээ болоод яваад очиход тэнд хадам ээж үргэлж хэн нэгэнтэй хэрэлдэж байна. Гэр дотор хэрүүл гарахад хадам ээжийн уурыг намдаах гэж нөхөр бид хоёр газар өвдөглөн сууж уучлалт гуйх бол энүүхэнд.

Мөн хадам ээж маань миний дараад тавьсан кимчиг надад хэлэлгүй хөршийхөнд тараах,

намайг эзгүй үед ойр хавийн хүмүүсийг цуглуулж найр хийх зэргээр дураараа аашлана. Хэрвээ одоогийн би тухайн үед байсан бол хадам ээждээ хандан: “хөршүүддээ эелдэг хандсанд баярлалаа” гэж хэлэх байсан. Гэвч тухайн үед хадам ээжийн маань үйл хөдлөлүүд надад огт таалагддаггүй байв. Мөн зээлээр худалдан авалт их хийдэг байсан тул сарын эцэс болохоор би дэлгүүрүүдээр явж тооцоог нь хийнэ. Хадам ээж ийм хүн байсан боловч нөхөр маань ээждээ туйлын хүндэтгэлтэй хандана. Өдөр бүр ээжид амттан худалдан авчирч өгөхөөс гадна хоол идэх үеэр загасыг яснаас нь нямбайлан салгаж, ясгүй хэсгийг нь ээжийн будаан дээр тавьж өгдөг байв.

Би нэг удаа “хадам ээжийн байр байдлыг тэвчихгүй нь” гэж нөхөртөө гомдоллоход “тэгтлээ тэсэхэд бэрх байгаа бол надаас салаад шинэ амьдралаар амьдраад үзэх юмуу” гэж хэлэв. Аргаа барсан би төрсөн ээждээ учир байдлаа хэлэхэд ээж маань “тэвчих л хэрэгтэй” гэж хэлсэн юм. Гэвч үнэндээ ээж маань дотроо надад маш их санаа зовж, “гэртээ хариад ирээсэй” гэж бодож байсан гэдэг.

Том хүүгээ олоод байхдаа би хэт их стресст орсноос болж, жирэмсний хүнд хэлбэрийн хордлогонд орж, гэр бүлээрээ эмнэлэг дээр цуглав. Эмч шууд л “эх хүүхдийн алийг нь сонгох вэ?” гэж асуусан гэдэг. Гэтэл хадам ээж “хүүхдээ сонгоноо” гэж хэлээд төрсөн ээжтэй маань ширүүн муудалцсан гэж дараа нь сонссон. “Дахин төрөх боломжгүй” гэж эмч надад хэлсэн боловч би хоёр дахь хүүгээ ч эрүүл саруул төрүүлж чадсан юм.

Том хүүгээ 5, бага хүүгээ 3тай байхад нөхрийн маань ажил жаахан урагшгүй байсан тул би давхар ажиллахаар болсон юм. Ажиллаж эхэлсэн үеэсээ л гэрийн ажил, хүүхдүүдийнхээ хоолыг урьдчилаад бэлдчихдэг байсан тул хадам ээжээс туслалцаа аваагүй гэсэн бардам бодол миний дотор байдаг байв.

83 насандаа хадам ээж маань насны доройтол болж хэвтэрт оров. Нөхөр маань хамаг чадлаараа ээжийгээ асарсан юм. Би ч гэсэн хадмыгаа асарсан боловч тэр бол өөрөө хүссэн

# Spiritual Journey

гэхээсээ илүү бэр хүний үүрэг гэсэн утгаараа хийсэн үйлдэл байв. Тийм болохоор хадмыгаа нас барахад дотроо “ачийг нь хангалттай хариулсан, одоо өөрийн дураар амьдарч болно” гэж бодсон. Гэвч бурханы сургаалаас суралцах явцад хадам ээжийнхээ сэтгэлийг ойлгоё гэж бодож байгаагүйгээ анзаарсан.

Хадам ээж маань 39 насандаа нөхрийгөө алдаж, 3 хүүхдээ дагуулан Хойд Солонгосоос Өмнөд Солонгос руу дүрвэн ирсэн гэдэг. Дайны дараах хүнд хэцүү үед жаахан хүүхдүүдтэй үлдсэн ганц бие эмэгтэй хүн амьд үлдэхийн тулд зан чанар нь ширүүн болохоос ч өөр арга байгаагүй болов уу. Ингээд бодохоор хамдынхаа сэтгэлийг бага ч болов ойлгох шиг болно. Нөхөр маань хадам ээжийн бурханаас залбиран мөргөж байж тээсэн том хүү нь байв. 7 настай байхад аав нь бурхан болсон ба хэдэн хүүхдээ өсгөх гэж зүдэрч байсныг нь багаасаа харж өссөн тул ээжийгээ маш их хайрладаг байв. Нөхрийн маань ээждээ хандах хандлага манай хөршүүдийн дунд хүртэл алдартай байсан юм.

Нөхөр маань одоо ээжийгээ хайрладаг байсан шиг намайг хайрлан халамжилдаг. Уур хилэнд автсан байсан дээр үеийн би нөхрийнхөө тэрхүү сэтгэлийг анзааралгүй, хадамдаа атаархдаг байсан байж магадгүй.

Энэ завшааныг ашиглан тэнгэрт хальсан хадам ээжээсээ уучлал гуйж, нүглээ наманчилья. Түүнчлэн намайг үргэлж дэмждэг байсан төрсөн ээждээ талархал илэрхийлж, санааг нь зовоож байсандаа хүлцэл өчье.

2016 оны 4 сард Нивано ерөнхийлөгч Солонгосын РКК-д айлчлан ирсэн юм. Ерөнхийлөгчийн буяны хишгээр манай дүүрэгт 10-н айл шинээр элсэн орсон билээ. Шинээр элссэн гишүүд маань янз бүрийн асуудалтай хүмүүс байсан боловч ихэнх нь асуудал хүүхдүүдтэй холбоотой байв. Тэдгээр хүмүүс РКК-д элсэж, Шүтээнээ гэртээ залмагц бурхан багш ар араас нь уран арга хэрэглэж эхлэв.

Нэг гишүүн хүү нь сайн газарт ажилд орлоо гэхэд нөгөө гишүүн хүү нь албан тушаал дэвшлээ, авч чадахгүй байсан зээлээ эргүүлэн авч чадлаа гэх мэтээр баяртай мэдээ ар араасаа цуварч эхлэв. Түүнчлэн шинээр элссэн

гишүүдээс РКК-н хамт олон “гэр бүл шиг халуун дулаан” гэсэн магтаалыг сонсов.

Бурханы сургаалыг тэр дор нь хэрэгжүүлж байгаа шинэ гишүүдээ хараад би төлөв даруу байдлаа мартаж орхисноо анзаарсан юм. Тэднээсээ би бурханы сургаалд талархах сэтгэл, дармаг байнга санаж явахын чухлыг сурсан. Одоо надад шинэ гишүүд маань бүгд эрхэм нандин санагддаг.

Нэг дүүрэгт амьдардаг болохоор тэд маань намайг байнга харж байдаг. Тиймээс хойшид би сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэн өөрийн үйлдлээрээ гишүүддээ үлгэрлэж явахаа тангараглаж байна.

2016 оны 5сард Токиод байрлах төв байгууламж дээр зохион байгуулагдсан Дэлхийн Санга нарын 4-р их чуулган оролцох үеэр биднийг маш халуун дотноор хүлээн авч, үйлчилсэн. Тэнд бид олон орны хүмүүстэй хамтдаа хэл, соёлын ялгааг давж, ижил сургаалын замаар алхаж байгаа номын андууд гэсэн утгаараа сайхан холбоо тогтоосон. Үнэхээр сайхан дурсамж болж үлдсэн.


Миний бие хойшид ч гэсэн олон хүнд энэхүү гайхалтай сургаалыг дамжуулж, хамтдаа аз жаргалтай болохын төлөө хичээх болно. Анхаарал тавин сонссон та бүхэнд баярлалаа.



*Хэсгийн ахлагч болсноосоо хойш судар голлон уншихдаа чадварлаг болсон.*



Living the  
**LOTUS**





# Child Care lifeline

## Үхлийн тухай асууж байгаа хүүхдэдээ юу гэж хариулахаа мэдэхгүй байна

**Q** Сүүлийн үед харгис балмад явдал их гарах болсон. Бага сургуулийн 4-р ангийн 10 настай охин маань сургууль болон мэдээгээр иймэрхүү яриа сонссон болохоор тэр үү “үхвэл яах вэ?”, “яагаад хүн хороодгийн болоо? “гэх зэрэг олон төрлийн асуултуудыг надад тавьдаг болов. Би “хүүхдүүд тийм зүйлийг анхаарсны хэрэггүй” гэж хариулдаг боловч ийм үед юу ярьсан нь дээр юм болоо?



**A** Хүүхэдтэйгээ “амь нас болон үхлийн талаар ярилцсан байхнээ. Олдсон боломжийг зүгээр өнгөрөөлгүй харин ч миний охин чухал газрыг олж анзаарсан байна. Яагаад хүн нас барж, хүн хороодог юм бол оо? Ээжтэйгээ хамтдаа бодъё гэж хэлээрэй.

Энэ асуултанд оносон жинхэнэ хариултыг олно гэдэг хэцүү ч гэсэн ганц асуултанд баригдалгүйгээр, охиноо мэндэлж байх үеийн баяр хөөр, хамтдаа өнгөрүүлсэн жаргалтай мөч, ойрын хүн өөд болох үеийн уйтгар гуниг, өвөг дээдэс үргэлж харж хамгаалж байдаг талаар ярьж үзвэл ямар вэ.

Хамгийн гол нь энэ асуултын ачаар амь насны үнэ цэнэ, одоо амьд мэнд амьдарч буйдаа талархах, мөн эх хүн хүүхдээ хичнээн их хайрлаж байдгийг дамжуулах явдал гэж бодож байна. Түүгээр л “амь нас ямар чухал зүйл болохыг ойлгодог хүүхэд болохгүй гэж үү. Түүнчлэн “үнэт амь нас болохоор өдөр болгон найз нартайгаа дотно байж, бусдын төлөө нийгмийн төлөө хүн болох нь чухал хэмээн хүнтэй эв найртай, нийгэмд ач тустай байх талаар ярьж өгөх хэрэгтэй.

Болж өгвөл шарил эргэх, цагаан сарын анхны мөр гаргах үеүдэд нүдэнд харагдахгүй ч өвөг дээдэс, бурхан багш биднийг үргэлж хамгаалж байдаг” тухай ярьж өгөх хэрэгтэй. Хүүхдэд нүдэнд харагдахгүй зүйлд хүнлэг

хандах сэтгэл зүй нэн чухал гэж бодож байна. Иймэрхүү зүйлийн талаар үр хүүхдэдээ зааж сургах нь эцэг эхийн том үүрэг юм.



### Point Амь насны үнэ цэнийн талаар ярих

Сэтгэл хөдөлгөсөн зүйл ой тойнд бат үлддэг. Энэ насанд эцэг эхтэйгээ ярилцсан зүйл насанд хүрсэн хойно ч амьдралд нь хэрэг болох учиртай. Тиймээс амь насны үнэ цэнэ, түүнийг хорвоод мэндлэхэд хэрхэн баярлаж байсан тухайгаа хайраа шингээн ярьж өгөөд үзээрэй.

Токио гэр бүлийн сургалт, судалгааны институт

Токио гэр бүлийн сургалт, судалгааны институт нь “Эцэг эх өөрчлөгдөх юм бол хүүхэд ч гэсэн өөрчлөгдөнө” гэсэн сурган хүмүүжүүлэх арга ухаанд тулгуурлан газар газарт сургалт семинар зохион байгуулж, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх талаар зөвлөгөө өгч байна. Үүгээр дамжуулан олон хүмүүс хүүхдээрээ дамжуулан гэр бүл гэж ямар байдгийг суралцаж, аз жаргалтай гэр бүл олноор төрж байна.



# Director's Column

## Шинэ оны зорилт


Та бүгдэд шинэ оны мэнд дэвшүүлье. Шинэ он гармагц тэмдэглэлийн дэвтэр, хуанли зэргээ шинэчилдэгийн адилаар сэтгэл санаа ч шинэхэн болсон мэт санагдана. Шинэ жил бол “Ямар амьдралаар амьдрахыг хүсч байна вэ?”, “Тэр амьдралаа бий болгохын тулд энэ жил би юуг зорих ёстой вэ?”, “түүнчлэн юуг хийж бүтээх ёстой вэ?” гэх зэрэг чухал асуудлуудыг эргэцүүлэн боддог үнэ цэнэтэй үе гэж би боддог.

Амьдралд тохиолдох бүх зүйл Бурхан багшийн надад зориулан айлдаж буй сургаал гэгддэг. Энэ бол Цагаан Лянхуа судрын үндсэн ойлголт. Бидний үзэсгэлэнтэй дэлхий дээр одоо болтол урсаж буй цус, нулимс нь залхуурч, хойш сууж болохгүй гэдгийг надад байнга сануулдаг. Зөвхөн өөрийн улсын эрх ашгийг боддог улс төрчдөд саналаа өгч байгаа хүмүүсийн сэтгэл нь бүх зүйл хоорондоо харилцаа холбоотой хэмээх хорвоогийн хуулийг анзаарахгүй байгаа миний харанхуй мунхаг сэтгэлийн илэрхийлэл гэж бодож байна.

Шинэ жилийг угтахдаа би өөрийнхөө амьдралдаа зорилго болгодог 3-н зүйлийг дахин өөртөө амладаг. Үүнд “дэлхийн хэмжээнд бурханы сургаалыг түгээх”, “өөрийн эх орон болох Япон улсыг бодьсатвагийн орон болгох”, “өөрийн биеийг бурханы сургаалд шамдахад зориулах” гэсэн зүйлс багтана. Түүнчлэн бүх хүн төрөлхтөний эв найрамдал, аз жаргалын төлөө зүтгэх болно. Энэ жил ч гэсэн та бүхэнтэйгээ хамт шамдан хичээе гэж бодож байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга  
Мизүтани Шёокоо

## Рисшо Косей Кай



🌸 RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES 🌸

# Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

# 2017

## Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

## Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles  
CA 90033 U.S.A

Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437  
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

### Branch under RKINA

#### Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.

Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261

e-mail: rkseattle@juno.com

http://www.buddhistLearningCenter.com

#### Rissho Kosei-kai of Vancouver

#### Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.

Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745

e-mail: dharmasanantonio@gmail.com

http://www.rkina.org/sanantonio.html

#### Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA

Tel: (727) 560-2927

e-mail: rktampabay@yahoo.com

http://www.buddhismtampabay.org/

## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.

Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633

e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

#### Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.

Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

#### Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.

Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.

Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567

e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

#### Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

#### Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

#### Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

#### Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

#### Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.

Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437

e-mail: info@rksf.org http://www.rksf.org

#### Rissho Kosei-kai of Sacramento

#### Rissho Kosei-kai of San Jose

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.

Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499

e-mail: rkny39@gmail.com http://rk-ny.org/

#### Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.

Tel: 1-773-842-5654

e-mail: murakami4838@aol.com

http://home.earthlink.net/~rkchi/

#### Rissho Kosei-kai of Fort Myers

http://www.rkftmyersbuddhism.org/

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.

Tel & Fax: 1-405-943-5030

e-mail: rkokdc@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

#### Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls

1660 Portland St. Klamath Falls, OR 97601, U.S.A.

#### Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1571 Race Street, Denver, Colorado 80206, U.S.A.

Tel: 1-303-810-3638

#### Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

635 Kling Dr, Dayton, OH 45419, U.S.A.

http://www.rkina-dayton.com/

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,

CEP 04116-060, Brasil

Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Fax: 55-11-5549-4304

e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

#### Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,

CEP 08730-000, Brasil

Tel: 55-11-5549-4446/55-11-5573-8377

## Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongzheng District, Taipei City 100, Taiwan

Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

http://kosei-kai.blogspot.com/

#### Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,

Taichung City 401, Taiwan

Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

## Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan

Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

#### Rissho Kosei-kai of Pingtung

## Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea

Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696

e-mail: krkk1125@hotmail.com

#### Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea

Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

## Branches under the Headquarters

#### Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,

North Point, Hong Kong,

Special Administrative Region of the People's Republic of China  
*Tel & Fax:* 852-2-369-1836

**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,  
Ulaanbaatar 15160, Mongolia  
*Tel:* 976-70006960  
*e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Sakhalin**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk  
693005, Russian Federation  
*Tel & Fax:* 7-4242-77-05-14

**Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia  
*Tel & Fax :* 39-06-48913949  
*e-mail:* roma@rk-euro.org

**Rissho Kosei-kai of the UK**

**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy

**Rissho Kosei-kai of Paris**

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France

**International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
*Tel:* 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224  
*e-mail:* ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibt-rk.org/>

**Rissho Kosei-kai of South Asia Division**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami, Tokyo, 166-8537, Japan  
*Tel:* 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

**Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand  
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218  
*e-mail:* thairissho@csloxinfo.com

**Branches under the South Asia Division**

**Rissho Kosei-kai of Central Delhi**

224 Site No.1, Shankar Road, New Rajinder Nagar, New Delhi,  
110060, India

**Rissho Kosei-kai of West Delhi**

66D, Sector-6, DDA-Flats, Dwarka  
New Delhi 110075, India

**Rissho Kosei-kai of Kolkata**

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,  
Kolkata 700094, India

**Rissho Kosei-kai of Kolkata North**

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,  
West Bengal, India

**Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center**

Ambedkar Nagar, West Police Line Road  
Rumpur, Gaya-823001, Bihar, India

**Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,  
Kathmandu, Nepal

**Rissho Kosei-kai of Singapore**

**Rissho Kosei-kai of Phnom Penh**

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,  
Phnom Penh, Cambodia

**Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand  
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218  
*e-mail:* info.thairissho@gmail.com

**Rissho Kosei-kai of Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
*Tel & Fax:* 880-31-626575

**Rissho Kosei-kai of Dhaka**

House#408/8, Road#07(West), D.O.H.S Baridhara,  
Dhaka Cant.-1206, Bangladesh  
*Tel:* 880-2-8413855

**Rissho Kosei-kai of Mayani**

Maitree Sangha, Mayani Bazar, Mayani Barua Para, Mirsarai,  
Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Patiya**

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Domdama**

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Cox's Bazar**

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

**Rissho Kosei-kai of Satbaria**

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Laksham**

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,  
Bangladesh

**Rissho Kosei-kai of Raozan**

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Chendirpuni**

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Ramu**

**Rissho Kosei-kai Dhamma Foundation, Sri Lanka**

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralessgamuwa, Sri Lanka  
*Tel & Fax:* 94-11-2826367

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**

**Rissho Kosei-kai of Habarana**

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

**Other Groups**

**Rissho Kosei-kai Friends in Shanghai**